

БАТЛАВ.
ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

С.ЧИНЗОРИГ

Б.ЭНХБАЯР

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсад хүний болон мал, амьтны зориулалттай эм, биобэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиар зохицуулж байна. Анх 1998 онд баталсан Эмийн тухай хуульд 2006 онд нэмэлт, өөрчлөлт оруулж Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль болгосон бөгөөд 2010 онд тус хуулийг шинэчлэн найруулснаас хойш нийт 6 удаа нэмэлт, өөрчлөлт орсон.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д туссаны дагуу Засгийн газраас 2019 оны 5 дугаар сарын 03-ны өдөр Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Хуулийн төслийг Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх явцад өргөн мэдүүлсэн хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнээс хальсан зарчмын зөрүүтэй саналууд гарсан тул хуулийн төслийг Засгийн газар дахин боловсруулахаар буцаан татсан.

Ийнхүү Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахад дараах хууль зүйн үндэслэлийг харгалзан үзсэн болно:

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.1.12-т “Эмнэлгийн хэрэгсэл, эм, вакцин, биобэлдмэлийн үйлдвэрлэл, худалдаа, экспорт, импортод тавих стандартын шаардлага, хяналт, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгож, дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлж, биотехнологийн цогцолбор байгуулах замаар чанар, аюулгүй байдлыг хангана.” гэж;

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.2.8-д “Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих,

архи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх судалгаа, мэдээлэл, сургалт сурталчилгааны салбар хоорондын хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлнэ.” гэж, 2.2.23-т “Монголын уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлж экспортод гарах гарцыг дэмжин “брэнд” болгох” гэж;

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2.2.7-д “эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангах, хангамж хүртээмжийг нэмэгдүүлэх хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.” гэж; Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.8-д “Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлнэ.” гэж заасан байна.

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2.1.8-д “Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлнэ.” гэсэн зорилтын хүрээнд “Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл хяналтыг нэвтрүүлэх”, “Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн зохицуулалт хийх.”, “Эмийн чанар, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ боловсруулж, хэрэгжүүлэх”, “Нянгийн тэсвэржилтийн хяналтын дэлхийн сүлжээнд нэгдэж, нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээг хянах тогтолцоог бүрдүүлэх”, “Төр хувийн хэвшлийн түншлэлийн тэргүүлэх чиглэлийг үндэслэн эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих”, “Биобэлдмэлийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх”, “Эмийн аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори байгуулах”, “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанар аюулгүй байдал, бүртгэл, засвар үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх” зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тус тус заасныг үндэслэл болгов.

1.2.Практик шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 22 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 222 дугаар тогтоолоор эм, биобэлдмэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын чиг үүргийг цогцоор хэрэгжүүлэх Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрыг байгуулж, Засгийн газрын 2021 оны 378 дугаар тогтоолоор мэргэжлийн хяналтын эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн хяналт шалгалтыг гүйцэтгэх чиг үүргийг тус агентлагт шилжүүлсэн. Эдгээр өөрчлөлттэй холбоотой зохицуулалтыг Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд тусгах, бусад хуультай уялдуулан чиг үүргийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах шаардлага бий болсон.

Өнөөгийн байдлаар Монгол Улсад 3400 гаруй нэр төрлийн эм импортоор, 1000 орчим нэр төрлийн эмийг дотоодод үйлдвэрлэж байна. Эдгээр эмийн чанар, аюулгүй байдал, үйлчилгээний идэвхийг бодитойгоор үнэлж, дүгнэлт гаргах лавлагаа лабораторийн чадавх бэхжээгүй, эм үйлдвэрлэх, хадгалах, түгээх, худалдах зохистой дадал бүрэн хэвшээгүй зэргээс шалтгаалан эмийн чанар, аюулгүй байдал, үйлчлэлийн идэвхийн баталгааг хангах үйл явц сул, хүн амын дунд эмийн чанар, үйлчлэлд үл итгэх,

эргэлзэх хандлага гарсаар байна. 2022 оны байдлаар эмийн 26 үйлдвэрийн ердөө 9 буюу 35 хувь нь эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын шаардлага хангаж байна¹. Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн үр дагаварт 2021 онд хийсэн Аудитын гүйцэтгэлийн үнэлгээнд импортын эмийн 6.1 хувь, дотоодод үйлдвэрлэсэн эмийн 18.6 хувь нь чанарын шаардлага хангахгүй байна гэж дүгнэсэн. Түүнчлэн хуурамч, стандартын бус эмтэй тэмцэх үүрэг хариуцлагыг тодорхойлсон хуулийн зохицуулалт байхгүй байгаа талаар үнэлгээнд дурдсан байна. Иймд Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд эм, биобэлдмэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгслийн чанарыг баталгаажуулахтай холбогдсон зохицуулалтыг олон улсын практикт нийцүүлэн тусгах шаардлага байна.

Дэлхийн эрүүл мэндийн ассамблейн 2018 оны 71 дүгээр чуулганаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд иргэний шууд төлөх зардлыг багасгахад чиглэсэн бодлого хэрэгжүүлэхэд эмийн үнийн ил тод байдлыг хангах, эмийн үнийг зохицуулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхийг улс орнуудад уриалсан.

Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2023 оны 20/А/95 дугаар тушаалаар Эрүүл мэндийн яам, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Стандарт, хэмжил зүйн газар хамтран ажлын хэсэг байгуулж, Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үнэ бүрдэлт, чанарын өнөөгийн байдалд хяналт шалгалт, үнэлгээ хийсэн. Хяналт шалгалт, үнэлгээнд эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй эм олгож буй 223 эмийн сан, 109 эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага, 19 эмийн үйлдвэр, 12 аймгийн нэгдсэн эмнэлэг, 5 бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нийт 368 байгууллага, аж ахуйн нэгжийг хамруулсан бөгөөд 2022 онд хамгийн их хэмжээгээр импортлогдсон олон улсын нэршлээр 50, худалдааны нэршлээр 240 эмийн гаалийн үнээс жижиглэнгийн үнэ хүртэлх нэмэгдэх хувь хэмжээг судалсан.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр эмийн үнэ үйлдвэрлэгчтэй байгуулсан хэлцлийн үнээс эцсийн хэрэглэгчид хүрэхдээ дунджаар 2.1 дахин нэмэгдсэн, үнэлгээнд хамрагдсан эмийн 80 хувьд өртөг үнэ дээр 30 хүртэл хувь нэмж ханган нийлүүлэх байгууллагууд борлуулсан, 20 хувьд бөөний үнийн нэмэгдэл 30-аас дээш хувь байна.

Эмийн жижиглэнгийн үнийн хувьд үнэлгээнд хамрагдсан эмийн 90 гаруй хувьд 45 хүртэл хувиар нэмэгдсэн, дотоодын үйлдвэрийн дийлэнх эмийн бөөний үнэ 40-өөс дээш хувиар нэмэгдсэн үзүүлэлт гарсан. Иймд иргэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахдаа санхүүгийн эрсдэлд орохоос сэргийлэх, бууруулах зорилгоор эмийн үнийн зохицуулалтын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага байна.

Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшгийн үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нөөцийн бэлэн байдлыг хангах, яаралтай горимоор тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх эм, эмнэлгийн хэрэгслийг бүртгэх, хадгалах, эмийн нөөц бүрдүүлэхтэй холбогдсон эрх зүйн зохицуулалтыг илүү оновчтой болгох шаардлагатай байгааг 2020 оны коронавируст халдварын цар тахлын сургамж харуулсан. Тухайлбал, 2021 оны 12 дугаар сард коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үеийн эрүүл мэндийн

¹ Эм, эмнэлгийн хяналт зохицуулалтын газрын 2022 оны үйл ажиллагааны тайлан.

тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах үйл ажиллагааны хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудад 15 нэр төрлийн эм, 6 нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл тодорхой хугацаанд нийлүүлэлт тасалдсан, бүтээгдэхүүний үйлдвэрийн үнэ 45 хувь, ханшийн зөрүү 14 хувь, тээврийн зардал 156 хувь, үйл ажиллагааны зардал 30 хувь тус тус өссөнөөс эмийн үнэ дунджаар 80 гаруй хувиар нэмэгдсэн тоо баримт байна². Түүнчлэн дэлхийн зах зээлд эмийн хомсдол үүсэх, экспортын хориг тавих зэрэг бусад хүчин зүйл нь үнийн өсөлтөд нөлөөлж байна. Иймд гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, иргэнд учрах санхүүгийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор эмийн нөөц, хангамжийг зохицуулах хэрэгцээ бий болж байна.

Дэлхийн 170 орон уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдүүлснээс 124 орон ургамлын гаралтай эм, түүхий эдийн талаар тусгайлсан зохицуулалттай байна. Хүчин төгөлдөр мөрдөж байгаа Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд уламжлалт эмийг эмийн сангаас гадуур худалдан борлуулах, түүхий эдийг бүртгэхгүй байх гэсэн уламжлалт эмийн талаар цөөн тооны тусгайлсан зохицуулалт байна. Түүнчлэн Үндэсний аудитын газраас “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд 2021 онд хийсэн үнэлгээгээр уламжлалт эм, түүхий эдтэй холбогдох эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгааг дүгнэж, цаашид эрх зүйн зохицуулалтын давхардал, хийдлийг арилгах зөвлөмж өгсөн.

Дэлхийн улс орнуудтай харьцуулахад хүн амын хувьд цөөн, эмийн зах зээл багатай манай улсын хувьд зарим эм, биобэлдмэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгслийг экспортлох зохицуулалт хуульд тусгагдаагүй байна. Иймд дотоодын бүтээгдэхүүний экспортыг дэмжих эрх зүйн зохицуулалтыг нэмэх шаардлагатай байна.

Дэлхий дахинаа техник, технологийн хөгжил асар хурдацтай явагдаж байгаа нь эрүүл мэндийн салбарт эмчилгээ, оношилгооны шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх хэрэгцээг улам нэмэгдүүлж байна. Иймд Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд эмнэлгийн хэрэгслийн бүртгэл, чанар, аюулгүй байдал, хөрөнгийн оновчтой төлөвлөлт, засвар үйлчилгээний менежмент зэрэг хууль, эрх зүйн зохицуулалтыг цогцоор нь тусгах хэрэгцээ бий болоод байна. Эрүүл мэндийн 142 байгууллагын 13 нэр төрлийн 1624 эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийхэд 15 орчим хувь хэмжил зүйн үзүүлэлт тэнцээгүй.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд хүн, мал, амьтны эмийн хяналт, зохицуулалтын асуудлыг хамтад нь тусгасан байдаг. Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дагаж мөрддөг бусад хууль хүний эрүүл мэндийн асуудлыг дангаар нь зохицуулж байгаа, Улсын Их Хуралд өмнө өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх явцад Улсын Их Хурлын гишүүдээс өгсөн чиглэл, санал болон бусад улсын жишгийг харгалзан, түүнчлэн энэхүү хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн урвалж оношлуур, нэг удаагийн эмнэлгийн хэрэгсэл, суулгац, протез зэрэг

² Монголын эм зүйн байгууллагуудын нэгдсэн “Эм” холбооны дотоодын эмийн үйлдвэрийн туншилтай эмийн үнийн өсөлтийн судалгаа

бүтээгдэхүүний зохицуулалтыг нарийвчлан тусгах практик шаардлагыг харгалзан хүний эмийн хяналт, зохицуулалтын асуудлыг мал, амьтны эмийн хяналт, зохицуулалтаас тусад нь хуульчлах хэрэгцээ, шаардлага байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан шинэчилсэн найруулга төслийн хэлбэрээр боловсруулна.

Олон улсын стандартын шаардлагыг хангасан эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагаанд орчин үеийн технологи болон зохистой дадлыг бүрэн нэвтрүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд өргөнөөр ашиглаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, нийлүүлэлт, засвар үйлчилгээ, ханган нийлүүлэлттэй холбогдсон харилцааг цогцоор нь зохицуулахад оршино.

1.Хуулийн зорилт, хууль тогтоомж болон энэ хуулиар зохицуулагдах эм, эмнэлгийн хэрэгсэлтэй холбогдох нэр томъёог ойлгомжтой, оновчтой байдлаар тодорхойлно.

2.Эм, эмнэлгийн хэрэгслийн талаар баримтлах бодлого, зарчмыг тодорхойлж, эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтын удирдлага, оролцогч талуудын чиг үүрэг, салбар дундын хамтын ажиллагааг тусгана.

3.Эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх, худалдах, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг (нэр төрөл, тунгийн хязгаар хамаарах) үйлдвэрлэх, импортлох, экспортлох үйл ажиллагаа эрхлэх болон эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ эрхлэхэд тавигдах шаардлага, тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг тусгана. Ялангуяа уламжлалт эмийн түүхий эд бэлтгэх, импортлох, байгалийн нөөц ашиглахтай холбогдсон зохицуулалтыг энэ хууль болон бусад дагалдах хуульд тусгахаар оруулна.

4.Эм, биобэлдмэлийн чанар, аюулгүй байдал, үйлчлэлийн идэвх, эмнэлзүйн судалгаа хийх, зах зээлд гаргах, зар сурталчилгаа явуулах эрх олгохтой холбогдсон зохицуулалт болон эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний (нэр төрөл, тунгийн хязгаар хамаарах) чанар, аюулгүй байдал, зах зээлд гаргах, зар сурталчилгаа явуулах эрх олгохтой холбогдсон үйл ажиллагааг заана.

5.Эмийн зохистой хэрэглээ, эм, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг (нэр төрөл, тунгийн хязгаар хамаарах) зах зээлд таниулах мэдээлэл, сурталчилгаа, эм, биобэлдмэлийн эмийн гаж нөлөө, сөрөг урвал болон зах зээлийн тандалт хийх, эмнэлгийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй ажиллагаатай холбогдсон зохицуулалтыг тусгана.

6.Эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн хангамж, хадгалалт, тээвэрлэлт, түгээлттэй холбогдсон зохицуулалтыг тусгана. Тухайлбал, улсын хилээр нэвтрүүлэх,

болзошгүй гамшиг, цар тахал гэх мэт нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, яаралтай нөхцөлд хэрэглэх эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн хангамжтай холбогдох харилцааг тодорхойлно.

7.Эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн хүртээмж, үнийн зохицуулалт, ил тод байдлын талаарх зохицуулалтыг тусгана.

8.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих мэргэжлийн хяналт, улсын байцаагчийн эрх үүрэгтэй холбогдсон харилцааг тодорхойлно.

9.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль тогтоомжийн зохицуулалттай холбогдсон харилцаанд хориглох зүйл, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааг заана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ батлагдсанаар эм, биобэлдмэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтыг хэрэгжүүлэгч талуудын чиг үүрэг тодорхой болж, чанар, аюулгүй байдлын зохицуулалт боловсронгуй болж, эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн хөөргөдөл буурч, иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахтай холбогдсон санхүүгийн эрсдэл буурна.

Эмнэлгийн хэрэгсэл, тухайлбал, тоног төхөөрөмжийн бүртгэл, нэршил, ангилал, чанар, аюулгүй байдал, шалгалт баталгаажуулалт, шалгалт тохируулга, хөрөнгийн төлөвлөлт, мэдээллийн сан, засвар үйлчилгээний менежментийн тогтолцоог зохицуулах боломж бүрдэнэ.

Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангахад төрийн чиг үүрэг, хариуцлага нэмэгдэж, уламжлалт эмийн зохицуулалт боловсронгуй болно.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хэрэгжиж эхэлснээр эм, биобэлдмэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалт олон улсын жишигт хүрэх ач холбогдолтой.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох хууль тогтоомжийн талаарх санал

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль тогтоомжтой нийцэн болно.

Уг хуулийн төсөлтэй уялдуулан Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай, Гаалийн тухай, Зөвшөөрлийн тухай, Зар сурталчилгааны тухай, Байгалийн ургамлын тухай, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай зэрэг хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

---oOo---